

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ТӨЛБӨРИЙН БАРИМТ ОЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

/Орхон аймгийн жишээ нь дээр /

Т.Элдэв-Очир*, Д.Отгонцэцэг**, У.Нандинцэцэг***

Хураангуй: Монгол улсын төсвийн орлогын дийлэнх нь татварын орлогоос бүрддэг, түүн дотроо нэмэгдсэн өртгийн албан татварын орлого нэлээдгүй хувийг бүрдүүлж байна. Манай улсад 2016 оноос эхлэн нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, урамшууллын системийг нэвтрүүлж эхэлсэн. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг Орхон аймгийн жишээн дээр авч үзлээ. Судалгааны ажлаараа төвлөрсөн зах худалдаа, үйлчилгээний төвүүдийн бизнес эрхлэгч иргэдийн төлбөрийн баримт гаргалтыг нэмэгдүүлэх боломж болон татварын албанаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг тодорхойлохыг зорилоо. Судалгаанд төвлөрсөн хүнс, бараа, барилгын материал, авто техникийн зах, бөөний худалдааны төв, гэр ахуйн худалдааны төв гэсэн Орхон аймаг дахь хамгийн том 6 төвлөрсөн зах, худалдааны төвийн бизнес эрхлэгч иргэдээс төлбөрийн баримт олголттой холбоотой хүндрэлтэй асуудал байгаа эсэх талаар авсан асуулга судалгаа болон дунджаар нэг бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримт олголт нь бизнес эрхэлж байгаа тухайн зах, худалдааны төвөөс хамааралтай байгаа талаар хийсэн вариацийн шинжилгээг тус тус авч үзсэн болно.

Орхон аймгийн бизнес эрхлэгч иргэд 100 хувь нэмэгдсэн өртгийн албан татварын удирдлагын нэгдсэн системд холбогдсон боловч татварын талаар мэдээлэл хангалттай буй, буруу ойлголттой байдгаас баримт гаргалт хангалттай түвшинд хүрдэггүй байна. Татварын албанаас шаг дараатай алга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр зарим төвлөрсөн зах худалдааны төвүүдийн баримт гаргалт нэмэгдсэн, иргэдээс ирэх гомдлын тоо болон зөрчлийн хэмжээ буурсан байна.

Түлхүүр үгс: Нэмэгдсэн өртгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын удирдлагын нэгдсэн систем, санал гомдол, цахим төлбөрийн баримт, зах худалдааны төв

WAYS TO INCREASE PAYMENT RECEIPTS BY BUSINESS OWNERS TO CITIZENS

/On the example of Orkhon province /

Abstract: Most of Mongolia's budget revenue consists of tax revenue, and value-added tax revenue accounts for a large percentage. In Mongolia, since 2016, the Law on Value Added Tax has been implemented and the incentive system has been introduced.

In this article, the indicators of the implementation of the value added tax law over the past 8 years have been considered on the example of Orkhon Province. Through research work, we aimed to determine the possibility of increasing the payment receipts of the business owners of the markets and service centers and the results of the measures taken by the tax authorities.

The results of the survey were collected from business owners of 6 large markets and shopping centers in Orkhon province such as food, goods, construction materials, technical utilities, wholesale shopping center, and household shopping center, and the results were compiled. Also, the variation analysis conducted on the dependence of the payment receipt issued by a business owner is considered.

Entrepreneurs of Orkhon province are fully connected to the integrated value added tax management system, but due to insufficient information and misunderstandings about taxes, the issuance of documents does not reach a sufficient level. As a result of the step-by-step measures implemented by the Tax office, the issuance of documents in some markets has increased, the number of complaints from citizens and the amount of violations have decreased.

Keywords; Value added tax, integrated value added tax management system, complaints, electronic payment receipts, market center

* "Эрдэнэт цйлдвэр" ТӨҮТ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail): eldevochir@erdenetis.edu.mn

** "Эрдэнэт цйлдвэр" ТӨҮТ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail): otgontsetse.d@erdenetis.edu.mn

*** "Эрдэнэт цйлдвэр" ТӨҮТ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail): 1981ngndia@gmail.com

Удиртгал

Татвар бол улс орны оршин тогтнох эдийн засгийн үндсийг бүрдүүлэх, төрөөс нийгмийн, ард иргэдийн сайн сайхны төлөө зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг. Тийм ч учраас татварын багц хууль хамгийн олон удаагийн өөрчлөгдсөн байна. Татварын энэ шинэчлэл нь эдийн засгийн, хөрөнгө оруулалт, бизнесийн өрсөлдөхүйц, таатай орчин бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн нэвтрүүлэх, татвар төлөгчдийн ачаалал бууруулах, татварын хялбаршуулсан горимыг нэвтрүүлж татварын бүртгэл, тайлагнал, төлөлтийг бүрэн цахимжуулах зэрэг давуу талуудыг бий болгосон. Үүний нэг тод жишээ бол нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид НӨАТ гэх)-ын тухай хууль томоохон өөрчлөлт оруулсан явдал юм.

НӨАТ нь аливаа улс орны хүн ам, аж ахуйн нэгж байгууллагуудыг үнэн зөв, санхүүгийн тайлан мэдээлэл бэлтгэдэг болгох, татварын хөндлөнгийн мэдээллийг цуглуулах найдвартай хэрэгсэл, эх үүсвэр болох, ингэснээр далд эдийн засгийг багасгах, төсвийн орлогыг бүрдүүлэх, хувь хүн, аж ахуй нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах ач холбогдол бүхий татвар юм. (Өнөржаргал.Ч, Гантулга.Г “НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй зарим асуудлууд”, 2010 он)

НӨАТ-ыг Монгол улсад нэвтрүүлснээс хойш улсын татварын орлогын 20-35 хувийг, дотоодын нийт бүтээгдэхүүний 5-7 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг дангаараа бүрдүүлж байна. Орхон аймгийн хувьд татварын орлогын 73 хувийг НӨАТ дангаар бүрдүүлж байна.

Тус аймгийн татвар хэлтэс НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор төвлөрсөн зах худалдаа, үйлчилгээний төвийн бизнес эрхлэгч иргэдийн баримт гаргалтад хяналт тавин ажиллаж байна. Судалгааны ажлаар Орхон аймгийн төвлөрсөн зах худалдаа үйлчилгээний төвүүдийн бизнес эрхлэгч иргэдийн төлбөрийн баримт гаргалтыг нэмэгдүүлэх боломж болон татварын албанаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг тодорхойлохыг зорилоо.

Судалгаанд төвлөрсөн хүнс, бараа, барилгын материал, авто техникийн зах, бөөний худалдааны төв, гэр ахуйн худалдааны төв гэсэн Орхон аймаг дахь хамгийн том 6 төвлөрсөн зах, худалдааны төвийн бизнес эрхлэгч иргэдээс төлбөрийн баримт олголттой холбоотой хүндрэлтэй асуудал байгаа эсэх талаар авсан асуулга судалгаа болон дунджаар нэг бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримт олголт нь бизнес эрхэлж байгаа тухайн зах, худалдааны төвөөс хамааралтай байгаа талаар хийсэн вариацийн шинжилгээг тус тус авч үзсэн болно.

Судалгааны арга зүй

Судалгаанд хамрагдсан 6 төвлөрсөн зах, худалдааны төвийн дунджаар нэг бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримт олголт нь тухайн зах, худалдааны төвөөс хамааралтай байгаа талаар энгийн бүлэглэлтийн нөхцөл дэх нэг хүчин зүйлийн вариацийн шинжилгээг ашигласан.

Эдийн засаг, статистикийн судалгаанд ашиглагддаг статистик таамаглалын тестийн нэг хэлбэр бол дисперсийн шинжилгээ (*ANOVA - analysis of variance — вариацийн шинжилгээ*) нь “хоёр буюу түүнээс дээш эх олонлогийн дунджууд нь хоорондоо тэнцүү” гэсэн анхдагч таамаглалыг “дунджууд нь ялгаатай буюу тэнцүү биш” гэсэн өрсөлдөгч таамаглалын нөхцөлд шалгадаг. (Grinnel college, 2024)

Дисперсийн шинжилгээ нь дисперсүүдийг харьцуулах арганд түшиглэх бөгөөд Фишерийн анх дэвшүүлсэн энэ арга нь туршилтын болон судалгааны өгөгдлийн хувьд тодорхойлогдсон квадратуудын нийлбэрийг дисперсийн хэсгүүдэд задалдаг.

Ерөнхий дисперс нь бүлгийн дундаж дисперс дээр бүлэг хоорондын дисперсийг нэмсэнтэй тэнцүү байна.
$$\sigma^2 = \sigma_i^2 + \delta^2$$

Энэ чанараас үндэслэн ерөнхий хэлбэлзэл нь бүлэглэлтийн болон үлдэгдэл хэлбэлзэлийн нийлбэртэй тэнцүү байна.

$SS(\text{Total}) = SST + SSE$ Энд :

$SS(\text{Total})$ – ерөнхий хэлбэлзэлийн квадратуудын нийлбэр ,

SST (*sum of squares for treatments*) – бүлэглэлтийн хэлбэлзэлийн квадратуудын нийлбэр,

SSE (*sum of squares for error*) - (алдаа) үлдэгдэл хэлбэлзэлийн квадратуудын нийлбэр болно.

Эдгээр хэлбэлзэлийн квадратуудын нийлбэрийг хэрхэн тооцох тухай авч үзье. Бүлэглэлтийг дараах байдлаар хийнэ:

Хүснэгт 1. Хэлбэлзэлийн квадратуудын нийлбэрийг тооцох бүлэглэлт

Бүлгүүд			
1	2	...	K
X_{11}	X_{12}	...	X_{1k}
X_{21}	X_{22}	...	X_{2k}
X_{31}	X_{32}	...	X_{3k}
.	.		.
X_{n_1}	X_{n_2}	...	X_{n_k}
n_1	n_2	...	n_k
\bar{X}_1	\bar{X}_2	...	\bar{X}_k

X_j - ажиглалтын утгууд, n_j - j-р бүлгийн варианты тоо, k - бүлгийн тоо, \bar{x}_j - j-р бүлгийн дундаж, $\bar{\bar{x}}$ - ерөнхий дундаж,

Дисперсүүдийг тооцоолохдоо тооцсон хэлбэлзлийн квадратуудын нийлбэрийг зохих чөлөөт гишүүдийн тоонд харьцуулна :

$$MST = \frac{SST}{k-1} = \frac{\sum_{j=1}^k n_j (\bar{x}_j - \bar{\bar{x}})^2}{k-1}; \quad MSE = \frac{SST}{n-k} = \frac{\sum_{j=1}^k \sum_{i=1}^{n_j} (x_{ij} - \bar{x}_j)^2}{n-k}$$


Дисперсүүдийг тооцоолсны дараа бүлэг хоорондын дисперс болон үлдэгдэл дисперсийн үнэлгээний хоорондох ялгааны ач холбогдлыг Фишерийн F тархалтаар тогтооно. F харьцаа нь ($F=MST/MSE$) олохдоо бүлэг хоорондын дисперсийн үнэлгээг үлдэгдэл дисперсийн үнэлгээнд харьцуулдаг. Дисперсийн шинжилгээнд “хоёр буюу түүнээс дээш эх олонлогийн дунджууд нь хоорондоо тэнцүү” гэсэн таамаглал нь анхдагч буюу тэг таамаглал болох бөгөөд тэг таамаглалыг “дунджууд нь ялгаатай буюу тэнцүү биш” гэсэн өрсөлдөгч таамаглалын нөхцөлд шалгадаг.

Өөрөөр хэлбэл анхдагч таамаглал нь $H_0 : \mu_1 = \mu_2 = \dots = \mu_k$ болох ба өрсөлдөгч таамаглал нь $H_1 : \mu_1 \neq \mu_2 \neq \dots \neq \mu_k$ болно. Фишерийн тархалтын хүснэгтээс өгөгдсөн α зөвшөөрөгдөх түвшин дэх онолын $F_{\alpha, k-1, n-k}$ утгыг олж тооцооны утгатай жишиж үзнэ. Хэрвээ тооцооны F утга онолын $F_{\alpha, k-1, n-k}$ утгаас бага байх юм бол H_0 таамаглалыг хүлээн зөвшөөрөх буюу эх олонлогийн дунджууд ($\mu_1 = \mu_2 = \dots = \mu_k$) тэнцүү болно. Энэ нь бүлэглэлтийн шинж тэмдэг ямар ч нөлөөгүй болохыг илтгэнэ. Эсрэгээр хэрэв тооцооны F утга онолын $F_{\alpha, k-1, n-k}$ утгаас их байх юм бол H_1 таамаглалыг хүлээн зөвшөөрөх буюу эх олонлогийн дунджууд ($\mu_1 \neq \mu_2 \neq \dots \neq \mu_k$) ялгаатай болно. Энэ нь бүлэглэлтийн шинж тэмдэг нөлөөтэй болохыг илтгэнэ. (Dominick salvatore, PhD, Derrick Reagle, PhD, Theory and Problems of statistics and econometrics, 2001)

Судалгааны хэсэг

НӨАТ нь далд эдийн засгийг бууруулах, төр өөрийн хяналтдаа мөнгөний урсгалыг байлгах арга зам гэж үздэг. Манай улсын хувьд 2023 оны байдлаар НӨАТ нь дотоодын нийт бүтээгдэхүүний (цаашид ДНБ гэх) 7 хувийг, нийт татварын орлогын 22 хувийг бүрдүүлж байна.

График 1. ДНБ болон нийт татварын орлогод эзлэх НӨАТ-ын хэмжээ (хувиар)




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Сүүлийн 9 жилийн дунджаар НӨАТ-ын орлого нь ДНБ-ний 6 хувь, нийт татварын орлогын 24 орчим хувийг дангаараа бүрдүүлж байна. НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 1 сарын 1-ээс эхлэн мөрдөж эхэлснээр цахим төлбөрийн баримтын E-barimt систем, татварын цахим тайлангийн etax.mta.mn системийн тусламжтайгаар борлуулалт, худалдан авалтын бүртгэл, НӨАТ ногдуулах аргачлал, тооцоолол амар хялбар болсон нь НӨАТ-ын орлого нэмэгдэх үндэс болсон. Сүүлийн 9 жилийн байдлаар НӨАТ-ын орлогын өсөлт дунджаар 22 хувь байна. 2019-2020 онуудад ковид цар тахлын нөхцөл байдалтай холбоотой тухайн татварын орлого буурсан ч сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн байна.

Орхон аймгийн хувьд нийт татварын орлогын дийлэнхийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ гэх) болон НӨАТ-ын орлого бүрдүүлдэг байна.

График 2. Орхон аймгийн татварын орлогод эзлэх НӨАТ-ын орлогын хэмжээ (хувиар)



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Орхон аймгийн хувьд нийт татварын орлогын 69-76 хувийг НӨАТ-ын орлого бүрдүүлж байна.

Тус аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар нийт 12,650 иргэн тогтмол үйл ажиллагаа явуулж байгаагаас 2.9 хувь буюу 339 иргэн нь суутган төлөгч байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгч иргэний 100 хувь нэмэгдсэн өртгийн албан татварын удирдлагын систем (цаашид НӨАТУС гэх)-д холбогдсон байна.

Орхон аймгийн сүүлийн 4 жилийн цахим баримт олголтыг авч үзвэл:

График 3. Орхон аймгийн цахим баримт олгох бизнес эрхлэгчид болон цахим баримт тогтмол олгодог бизнес эрхлэгчид




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Орхон аймгийн нийт бизнес эрхлэгчид 100 хувь татвар төлөгчийн НӨАТУС-д холбогдсон боловч төлбөрийн баримт олголтын хувь сүүлийн 4 жилийн дунджаар 71 хувьтай байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулах хөтөлбөрийн хүрээнд Монголын Татварын алба төлбөрийн баримтыг бүх нийтээрээ олгодог болгох хялбар шийдлийг нэвтрүүлж, төлбөрийн баримтыг худалдан авагч талд хэрхэн хүнд суртал, чирэгдэлгүйгээр олгох асуудлыг шийдэхийн тулд QR кодыг ашиглаж эхэлсэн.

Баг төвлөрсөн зах худалдаа, үйлчилгээний газрын бизнес эрхлэгч,лангуу түрээслэгчдийн ажлын байранд QR кодыг бүрэн байршуулах, посс машин, гар утасны аппликейшн ашиглан төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлсний үр дүнд 2023 онд баримт олголтын 85 хувь болж өссөн байна.

Төвлөрсөн зах худалдаа, үйлчилгээний төвийн бизнес эрхлэгчдийн сард гаргах баримт олголтыг бүлэглэн график №4-аар харуулав.

График 4. Бизнес эрхлэгчдийн баримт олголтын сарын дундаж тоо



Эх сурвалж :Судлаачийн тооцоо

Бизнес эрхлэгчид сард олгох баримтын тоог 5 бүлэг болгон авч үзэхэд 2020-2021 онуудад 500-аас бага баримт олгосон 141- 190 бизнес эрхлэгч буюу нийт баримт олгох ёстой иргэдийн 41-22 хувь, 500-аас дээш удаа баримт олгодог бизнес эрхлэгч иргэн 637-2022 буюу 59-78 хувь байсан. 2022 оноос бизнес эрхлэгчдийн төлбөрийн баримт олголтын тоо буурч нийт баримт олгох ёстой иргэдийн 83 хувь нь сард 100 доош баримт олгосон байна. Энэ нь жилийн борлуулалтын орлого 50 сая хүрэхэд НӨАТ-ын суутган төлөгч болохоос зайлсхийж нэг түрээсийн гэрээн дээр 2-3 иргэн төлбөрийн баримт гаргасан зөрчил ихэссэнтэй холбоотой байна.

Орхон аймгийн хэмжээнд насанд хүрсэн нийт 76.554 иргэний 89.5 хувь нь ибаримт аппликэйшний байнгын хэрэглэгч болсон. Ибаримт аппликэйшн хэрэглэгчдийн тоо 2021 оноос 2023 оны хооронд 51 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг дагаад буцаан олголт авдаг иргэдийн тоо болон буцаан олголтын дүн өссөн 2023 онд 21,355 иргэн 1,517.3 сая төгрөгийн НӨАТ-ын урамшуулал авсан байна. (Хувь хүний орлогын албан татвар татварын хөтөч , 2023 он) Иргэдийн 10.5 хувь ибаримтад бүртгэлгүй байна. Үүнээс 93.6 хувь нь гэр бүл, найз нөхдөрөө бүртгүүлдэг байхад үлдсэн хувь нь огт бүртгүүлдэггүй байна. Дээрх иргэд ухаалаг утасгүй, цахим системийг ашиглаж чаддаггүй, бүртгэлийг буруу хийснээс дахин ашиглах боломжгүй болсон, хөдөө сүлжээгүй газарт амьдардаг зэрэг шалтгаанаар төлбөрийн баримтыг бүртгүүлж чадахгүй байна.

Судалгаанд хамрагдсан төвлөрсөн зах худалдааны төвөөр үйлчлүүлдэг иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах, үйлчилгээ авахдаа төлбөрийн баримт авч чаддаг эсэх судалгаагаар 39.3 хувь нь тогтмол авдаг, 4.1 хувь нь огт авдаггүй, дийлэнх буюу 56.7 хувь нь төлбөрийн баримтаа хэвлэж өгөхгүй учраас бүрэн авч чаддаггүй гэх хариулсан. Ихэвчлэн зарим барилгын материалын дэлгүүр, сэлбэгийн дэлгүүр, үсчин, гоо сайхан, барааны лангуунууд огт өгөхгүй гэх хариулсан.

Төлбөрийн баримт олгоогүй, нэгдсэн системийн санд илгээгээгүй, үнийн дүнг зөрүүтэй олгосон иргэнийг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчлийн хэрэг үүсгэн хариуцлага тооцдог болсноор хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Орхон аймгийн татварын хэлтэс иргэдээс төлбөрийн баримт олголттой холбоотой санал, гомдлыг татварын удирдлагын нэгдсэн систем, 70353511 утсаар, цаасаар хүлээн авдаг ба гомдол барагдуулалт 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн баримт олголттой холбоотой иргэдээс ирсэн гомдлыг шийдвэрлэсэн байдал

Гомдол хүлээн авсан хэлбэр	2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Гомдлын тоо	Хувь	Гомдлын тоо	Хувь	Гомдлын тоо	Хувь	Гомдлын тоо	Хувь
ТУНС-ээр	1297	100%	4760	99.4%	2608	99.1%	2046	99.5%
70353511 утсаар			32	100%	26	100%	15	100%
Цаасаар			4	100%	5	100%	4	100%
Нийт	1297	100%	4796	99.4%	2639	99.1%	2065	99.5%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой татварын алба торгууль, албан шаардлагыг бизнес эрхлэгч иргэдэд хүргүүлэн шаардлагатай тохиолдол шийтгэлийн хуудсаар торгууль ногдуулж, тухайн зөрчлийн давтан гаргасан, гаргасан зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шүүхээр зөрчлийн тухай хуулиар шийтгэл ногдуулдаг байна.

График 5. Төлбөрийн баримт олгоогүй, баримтжуулаагүй шийтгэл ногдуулсан бизнес эрхлэгчийн тоо, торгуулийн хэмжээ



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дээрх үйл ажиллагааны үр дүнд 2021 онд шийтгэлийн хуудсаар 302 татвар төлөгчийг татварын хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 21.5 сая төгрөгийн шийтгэл ногдуулснаас 24 татвар төлөгч огт баримт олгоогүйгээс шийтгүүлсэн, 3 татвар төлөгчид зөрчлийн хэрэг үүсгэн 5.4 сая төгрөгийн шийтгэл хүлээсэн байна. 2022 онд 264 татвар төлөгчийн зөрчлийг хялбаршуулсан журмаар

шийдвэрлэж 115.2 сая төгрөгийн шийтгэл ногдуулсны 108 татвар төлөгчийн 40.1 сая төгрөг нь огт төлбөрийн баримт олгоогүйгээс үүссэн торгууль байсан. 2023 онд ногдуулсан шийтгэлийн 15.6 сая төгрөг буюу 25 татвар төлөгч огт баримт олгоогүйгээс торгуулсан байна.

Үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгч иргэдээс төлбөрийн баримтыг олгоход хүндрэл учирдаг эсэх талаар тодруулахад дараах шалтгаануудыг дурдаж байна. Үүнд:

- Хууль эрх, зүйн мэдлэг дутмаг
- Төлбөрийн баримт олгосноор НӨАТ төлөгч болно гэсэн ойлголттой
- Тухайн орон нутгийн бусад байгууллагууд баримт олгохгүй байгаа болохоор олгодоггүй
- Хэрэглэгч ибаримтаа шаарддаггүй.
- Худалдан авалт хийдэг хилийн болон томоохон захууд /Нарантуул, Хархорин, Зуун айл/ төлбөрийн баримт олгодоггүй нь төлбөрийн баримт олгохгүй байхад нөлөөлж байна.

Орхон аймгийн төвлөрсөн зах худалдаа, үйлчилгээний төвүүдээс байршил, бизнес эрхлэгч иргэдийн тоо, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь түүвэрлэн хамгийн том 6 зах худалдааны төвийг сонгон авч, дунджаар нэг бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримт олголт нь бизнес эрхэлж байгаа тухайн зах, худалдааны төвөөс хамааралтай байгаа талаар энгийн бүлэглэлтийн нөхцөл дэх нэг хүчин зүйлийн вариацийн шинжилгээг хийсэн болно.

Судалгаанд дараах тоо мэдээллийг ашигласан.

Хүснэгт 3. Түцвэрлэсэн 6 зах, худалдааны төвийн татвар төлөгчийн тоо болон олгосон баримтын тоо

№	Худалдааны төв	2020		2021		2022		2023	
		Нийт баримт олгож байгаа татвар төлөгчийн тоо	Баримтын тоо	Нийт баримт олгож байгаа татвар төлөгчийн тоо	Баримтын тоо	Нийт баримт олгож байгаа татвар төлөгчийн тоо	Баримтын тоо	Нийт баримт олгож байгаа татвар төлөгчийн тоо	Баримтын тоо
1	Хүлэг худалдааны төв	38	1,254	43	2,358	44	8,345	51	6,368
2	Үйлчилгээний төв	72	5,124	85	21,450	96	35,779	102	27,408
3	9 Эрдэнэ худалдааны төв	50	21,543	52	45,879	55	111,134	69	110,181
4	100 айл худалдааны төв	48	524	55	3,589	57	9,131	67	10,172
5	Даниста худалдааны төв	45	325	48	3,456	51	6,206	59	8,603
6	Төгөл худалдааны төв	68	958	72	4,021	76	9,691	85	12,867

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дээрх тоо мэдээллийг ашиглан бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримтын дундаж тоог зах, худалдааны төвүүдээр нь тооцож хүснэгт № 4 -д үзүүлэв.

Хүснэгт 4. Түцвэрлэсэн 6 зах, худалдааны төвийн татвар төлөгчийн олгосон баримтын дундаж тоо

	2020	2021	2022	2023
Хүлэг худалдааны төв	33	55	190	125
Үйлчилгээний төв	71	252	373	269
9 Эрдэнэ худалдааны төв	431	882	2021	1597
100 айл худалдааны төв	11	65	160	152
Даниста худалдааны төв	7	72	122	146
Төгөл худалдааны төв	14	56	128	151

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дээрх тоон мэдээллийг ашиглан “зах, худалдааны төвүүдийн бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримтын дундаж тоо нь тэнцүү” гэсэн анхдагч таамаглалыг “зах, худалдааны төвүүдийн бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримтын дундаж тоо нь ялгаатай буюу тэнцүү биш” гэсэн өрсөлдөгч таамаглалын нөхцөлд, 5 хувийн ач холбогдлын түвшинд шалгасан болно.

Эхлээд хэлбэлзлийн квадратуудын нийлбэрийг олъё:

$$SST = \sum_{j=1}^k n_j (\bar{x}_j - \bar{x})^2 = 4,178,735.69; \quad SSE = \sum_{j=1}^k \sum_{i=1}^{n_j} (x_{ji} - \bar{x}_j)^2 = 1,620,146.8$$

Чөлөөт гишүүдийн тоо нь :

$k-1=6-1=5$; $n-k=24-6=18$; $n-1=24-1=23$ болно. Эндээс дисперсүүдийг тооцвол :

$$MST = \frac{SST}{k-1} = \frac{4178735.69}{5} = 835,747.13$$

$$MSE = \frac{SSE}{n-k} = \frac{1620146.8}{18} = 90,008.15$$

ийм болно. Дисперсүүдийн харьцаа буюу (F statistic)-г олбол :

$$F = \frac{MST}{MSE} = \frac{835,747.13}{90,008.15} = 9.28$$

I төрлийн алдаа гарах магадлалыг 0.05-аар сонгож, Фишерийн тархалтын хүснэгтээс $\alpha=0.05$ ач холбогдлын түвшин дэх онолын $F_{0.05,2,17}=2.77$ гэсэн утгыг олж тооцооны утгатай жишиж үзвэл:

$$F = \frac{MST}{MSE} > F_{\alpha, k-1, n-k} \text{ буюу } 9.28 > 3.59 \text{ болж зах, худалдааны төвүүдийн}$$

бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримтын дундаж тоо нь ялгаатай буюу тэнцүү биш” гэсэн өрсөлдөгч таамаглалыг 5 хувийн ач холбогдлын түвшинд хүлээн зөвшөөрч байна. Тодруулбал дунджаар нэг бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримт олголт нь тухайн бизнес эрхлэгчид ямар зах, худалдааны төвд ажиллаж байгаагаас шалтгаалдаг гэсэн үг юм. Тухайлбал “9 эрдэнэ худалдаан төв” болон “Үйлчилгээний төв”-д ажилладаг бизнес эрхлэгчдийн төлбөрийн баримт олголт хамгийн их байгаа бол “Хүлэг зах”-ын бизнес эрхлэгчид хамгийн бага төлбөрийн баримт олгож байгаа ба бусад 4 зах, худалдааны төвийн хувьд төлбөрийн баримт олголт ойролцоо байна.

Иймээс төлбөрийн баримт бага олгодог дээрх зах, худалдааны төвүүд рүү илүү чиглэж ажиллах шаардлагатай байна.

Татварын хэлтэс Татварын ерөнхий газар болон аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жил бүр НӨАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэх заалтыг тусган баталсан байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн талаар 1 асуудал тусгаж, 93.8 хувийн хэрэгжилттэй байна. (Татвар хураалтын үйл ажиллагааны гарын авлага, 2023 он). НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Орхон аймгийн засаг даргын 2022 оны 03 сарын 09-ний өдрийн №А/101 тоот захирамжийн дагуу барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа болон туслан гүйцэтгэгч хувь хүн, хуулийн этгээдэд хяналт тавих, зөвлөгөө мэдээллийг хүргэх зорилгоор холбогдох ажлыг зохион байгуулж ажлын байранд сургалт, мэдээлэл хүргэж ажиллаж байна. Мөн төвлөрсөн зах худалдааны 22 төвүүдийн удирдлагуудтай “Зангиагүй уулзалт” уулзалтыг зохион байгуулан нийт 1211 түрээслэгч нарын түрээсийн гэрээнд хэрэглэгчдэд и-баримт хэвлэн өгч татварын хуулийг хэрэгжүүлэх тухай болон зөрчлийн тухай хуулийн 11.19 заалт нэмж оруулах талаар харилцан ярилцаж өөрчлөлтийг оруулахаар ажилласан байна. (Татвар хураалтын үйл ажиллагааны гарын авлага, 2023 он)

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуурт “Төлбөрийн баримт олгох” заалтыг оруулсан нь төлбөрийн баримт олголт нэмэгдэхэд нөлөөлж байна. Энэ нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо дээрх үзүүлэлтийг шалгуур заалтад нь оруулснаар төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэх боломжтой. Мөн аймгийн Татварын хэлтэс Санхүү, төрийн сангийн хэлтэстэй

хамтран ажиллаж, төсвийн байгууллагуудын ажил гүйлгээг төлбөрийн баримтад үндэслэн хийдэг болсноор төлбөрийн баримтын олголт өмнөх оноос нэмэгдсэн байна.

Мөн худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн хүнсний лангуундаа баримт олгож байгаа боловч барааны лангуундаа баримт олгодоггүй, татвар төлөгчөөр шаардуулж олгодог, зөвхөн төсвийн байгууллагад олгодог, хямдралтай бараанд олгодоггүй зэрэг нийтлэг зөрчлүүд байдаг.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай улсын улсын төсвийн орлогын дийлэнх хэсгийг татварын орлого бүрдүүлдэг бөгөөд 2023 оны байдлаар НӨАТ-ын орлого нийт татварын орлогын 22 хувь, ДНБ-ний 7 хувьтай хэмжээний орлого бүрдүүлсэн байна.

НӨАТ-ын тухай хуулийн шинэчлэгдсэнээр цахим төлбөрийн баримтын E-barimt систем, татварын цахим тайлангийн etax.mta.mn системийн тусламжтайгаар борлуулалт, худалдан авалтын бүртгэл, НӨАТ ногдуулах аргачлал, тооцоолол амар хялбар болсон нь НӨАТ-ын орлогыг 22 хувь өсгөсөн байна.

2023 оны байдлаар Орхон аймгийн хэмжээнд нийт 12,650 бизнес эрхлэгч иргэн тогтмол үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 2.9 хувь буюу 339 иргэн нь суутган төлөгч байна. НӨАТ-ын суутган төлөгч иргэний 100 хувь НӨАТУС-д холбогдсон хэдийн ч баримт олголт сүүлийн 4 жилээр авч үзэхэд 71 хувьтай байгаа нь хангалтгүй юм.

Бизнес эрхлэгчдийн сард гаргах баримт эргэлтийн тоо буурч 2022 оны байдлаар нийт бизнес эрхлэгч иргэдийн 83 хувь нь 100-аас доош баримт гаргасан байна. Энэ нь жилийн борлуулалтын орлого 50 сая хүрэхэд НӨАТ-ын суутган төлөгч болохоос зайлсхийж нэг түрээсийн гэрээн дээр 2-3 иргэн төлбөрийн баримт гаргасан зөрчил ихэссэнтэй холбоотой байна.

Судалгаанд хамрагдсан төвлөрсөн зах худалдааны төвөөр үйлчлүүлдэг иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах, үйлчилгээ авахдаа төлбөрийн баримт авч чаддаг эсэх судалгаагаар 39.3 хувь нь тогтмол авдаг, 4.1 хувь нь огт авдаггүй, дийлэнх буюу 56.7 хувь нь төлбөрийн баримтаа хэвлэж өгөхгүй учраас төлбөрийн баримт авдаггүй байна. Ихэвчлэн барилгын материалын дэлгүүр, сэлбэгийн дэлгүүр, үсчин, гоо сайхан, барааны лангуунууд огт өгөхгүй байна.

Төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой татварын алба торгууль, шийтгэлийн арга хэмжээ авч эхэлсний үр дүнд 2021 онд 305 бизнес эрхлэгч иргэн 26.9 сая төгрөгийн шийтгэл, 2022 онд 264 бизнес эрхлэгч иргэн 155.3 сая төгрөгийн шийтгэл, 2023 онд 131 бизнес эрхлэгч иргэн 76.6 сая

төгрөгийн шийтгэл ногдуулсан байна.

Орхон аймгийн төвлөрсөн зах худалдаа, үйлчилгээний төвүүдээс байршил, бизнес эрхлэгч иргэдийн тоо, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь түүвэрлэн 6 зах худалдааны төвийг сонгон авч үзэхэд баримт гаргалтыг бүлэглэн нэг хүчин зүйлийн вариацийн шинжилгээ хийж үзэхэд Дисперсүүдийн харьцаа 9.28, I төрлийн алдаа гарах магадлалыг 0.05-аар сонгож, Фишерийн тархалтын хүснэгтээс $\alpha=0.05$ ач холбогдлын түвшин дэх онолын утга 2.77-той харьцуулж үзэхэд $F > F_{\alpha, k-1, n-k}$ буюу $9.28 > 3.59$ гарсан нь зах, худалдааны төвүүдийн бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримтын дундаж тоо нь ялгаатай буюу тэнцүү биш гэсэн таамаглал 5 хувийн ач холбогдлын түвшинд батлагдсан. Энэ нь дунджаар нэг бизнес эрхлэгчийн олгож буй төлбөрийн баримт олголт нь тухайн бизнес эрхлэгчид ямар зах, худалдааны төвд ажиллаж байгаагаас хамаарч өөр байгаа тэр дундаа “9 эрдэнэ худалдаан төв” болон “Үйлчилгээний төв”-д ажилладаг бизнес эрхлэгчдийн төлбөрийн баримт олголт хамгийн их байгаа бол “Хүлэг зах”-ын бизнес эрхлэгчид хамгийн бага төлбөрийн баримт олгож байгаа ба бусад 4 зах, худалдааны төвийн хувьд төлбөрийн баримт олголт ойролцоо байна.

Баримт гаргалтын тоо бага байгаа Даниста, хүлэг худалдааны төвүүдийн лангуу түрээслэгч иргэдийн гэрээг түрээслүүлэгчтэй тулган нэг лангуу нэг татвар төлөгч гэсэн шаардлага тавих, түрээслүүлэгчтэй “Зангиатай уулзалт”, НӨАТ-ын хуулийн давуу талыг ухуулан сурталчлах замаар бизнес эрхлэгчдэд нөлөөлөх.

Орхон аймгийн татварын газрын нийт татварын улсын байцаагч нар төвлөрсөн зах худалдааны төвүүдээр ажиллаж ебаримт гаргалтыг шалгаж шаардаж ажиллах, татвар төлөгч хялбаршуулсан горимоор жилд нэг удаа 1 хувиар татвар төлөх тайлан илгээх арга зүй болон давуу талыг сурталчлан таниулах.

Иргэдэд төлбөрийн баримт авах нь ямар давуу талтай болохыг сурталчлан таниулж сургалт мэдээлэл, шторк, нэвтрүүлэг хийж ажилласан.

Татварын алба нь төлбөрийн баримт тогтмол авснаар бий болох давуу талуудыг сурталчлан таниулах, бизнес эрхлэгч иргэдэд хуулийн талаар зөв ойлголтыг өгөх, иргэдэд баримт олгох QR кодыг улам боловсронгуй болгох, төлбөрийн баримт гаргалт бага байгаа төвлөрсөн зах худалдааны төвүүдээр тавих хяналтаа тогтмолжуулах шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Dominick salvatore, PhD, Derrick Reagle, PhD, “Theory and Problems of statistics and econometrics” 2001, New York

Алтанзаяа.Г “Татварын бүртгэл” УБ, 2015 он

Өнөржаргал.Ч, Гантулга.Г “НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй зарим асуудлууд”, УБ хот, 2010 он

“Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан УБ хот, 2018 он

НӨАТ-ын тухай хууль, 2015 он

Орхон аймгийн татвар хураалтын үйл ажиллагааны гарын авлага, 2020-2023 он

Орхон аймгийн хувь хүний орлогын албан татвар татварын хөтөч, 2020-2023 он

<https://collinn.github.io/teaching/2024/lectures/anova.pdf>

<https://www.mta.mn/>

<https://www.1212.mn/>

<http://www.legalinfo.mn/>